

**ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /2-р сарын 26-нөөс 3-р сарын 26-ны байдлаар, төгрөгөөр/**

№	Барааны нэр, төрөл	II/26	III/05	III/12	III/19	III/26
1	Гурил, I зэрэг, кг	800	800	800	800	800
2	Хонины мах, кг/ ястай/	6800	6800	6800	7000	7000
3	Үхрийн мах, кг /ястай/				9000	
4	Ямааны мах /ястай /	5500	5500	5500	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1600
6	Цагаан будаа, кг	2100	2100	2100	2150	2150
7	Шингэн сүү, л	1500	1500	1500	1500	1500
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан				75000	85000
9	- Бор ноолуур				75000	85000
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 2-р сарын 26-наас 3-р сарын 26-ны хооронд хонь, ямааны ястай мах, цагаан будааны үнэ өсөв. Гурил, элсэн чихэр, шингэн сүү, шатахууны үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуур арилжиж эхэллээ.

**Махны үнэ.** Хонины 1 кг ястай мах 2-р сарын 26-наас 3-р сарын 12-ыг хүртэл 6800 төгрөгийн ханштай байсан бол 3-р сарын 19-нөөс 2,9 хувиар өсч 7000 төгрөг болов. Үхрийн ястай мах 3-р сарын 15-нд 1 кг нь 9000 төгрөгөөр зарж байсан бол 3-р сарын 26-нд зарагдсангүй. Ямааны ястай 1 кг мах 3-р сарын 19-нд өмнөх 3 долоо хоногийн ханшаас 9,1 хувь буюу 500 төгрөгөөр өсч 6000 төгрөг болов. **Гурил, элсэн чихэр, цагаан будаа.** Сүүлийн 5 долоо хоногийн туршид алтан тариагийн 1-р гурил, элсэн чихрийн дундаж үнэ тогтвортой байж өөрчлөгдөөгүй. Цагаан будааны дундаж үнэ 3-р сарын 19-нөөс 50 төгрөгөөр өсч 2150 төгрөг боллоо.

**Шингэн сүү.** Шингэн сүү сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой 1 литр нь 1500 төгрөгийн ханштай байна.

**Түлш шатахуун.** Шатахууны үнэ энэ хугацаанд өөрчлөгдөөгүй байна.



